



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1999 оны 12 дугаар
сарын 16 өдөр

Дугаар А-251

Улаанбаатар
хот

Хүнсний бөөний худалдааны
төв ажиллуулах зөвшөөрөл
олгох тухай

Нэг. Нийслэлийн Засаг даргын 1997 оны А/258 тоот захирамжаар баталсан "Хүнсний бөөний худалдааны төвийн журам"-ын дагуу хүнсний бөөний төв ажиллуулах зөвшөөрлийг нэгдүгээр хавсралтанд дурдсан аж ахуйн нэгжүүдэд олгох, хоёрдугаар хавсралтанд заагдсан аж ахуйн нэгжүүдийн эрхийг хүчингүй болгосугай.

Хоёр. Дээрх хүнсний бөөний төвүүдэд орчны тохижилт, ариун цэвэр, эмх цэгц, дэг журмыг зохих шаардлагын дагуу хангах талаар холбогдох гэрээ байгуулан ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нар, Захирагчийн ажлын албаны Хот тохижилтын хэлтэс /Г.Өлзий/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Э.Гомбожав/-нд даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ


М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 1999 оны
 тоот захирамжийн 1 -р хавсралт

**ХҮНСНИЙ БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ ТӨВ
 АЖИЛЛУУЛАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
 ЖАГСААЛТ**

Нэг. Сүхбаатар дүүрэг

- 1. БИМЭКС ХХК-ний хүнсний бөөний төв
- 2. СОНЖИ ХХК -ний хүнсний бөөний төв
- 3. СҮҮ ӨГӨӨЖ ХХК -ний хүнсний бөөний төв

- СБД 2-р хороо, Индэрт ХХК-ны байранд
- СБД 7-р хороо, Эрхүүгийн гудамж Алунгоо ХХК-ны байранд
- СБД 2-р хороо Улсын циркийн баруун талд

Хоёр. Чингэлтэй дүүрэг

- 1. Бишрэлттрейд ХХК-ний хүнсний бөөний төв

- ЧД 5-р хороо, хуучин Хүүхдийн хувцасны үйлдвэрийн байранд

Гурав. Баянгол дүүрэг

- 1. ЖСБ ХХК -ний хүнсний бөөний төв

- БГД 6-р хороо, 10-р хороололд

Дөрөв. Баянзүрх дүүрэг

- 1. ТЭРХ ИМПЭКС ХХК-ний хүнсний бөөний төв

- БЗД 7-р хороо, хуучин АҮТөвийн байранд



Нийслэлийн Засаг даргын 1999 оны
тоот захирамжийн 2 -р хавсралт

**ХҮНСНИЙ БӨӨНИЙ ТӨВ АЖИЛЛУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙГ
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖҮҮД**

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Захирамжийн дугаар заалт	Байрлал	Шалтгаан
1.	Даймонд ХХК	А\ 50	СБД 2-р хороо, Улсын циркт	Үйлчилгээний чиглэлээ өөрчилж биллиард клуб болгосон
2.	Евро Ази трейд ХХК	А\ 58 хавсралтын " 1"	СБД 8-р хороо, Ардын эрх сонины байр	Үйл ажиллагаа зогссон
3.	Мандал Алтай ХХК	А\ 58 хавсралтын " 3"	СБД 10-р хороо 100 айлд	Түрээсийн байрнаас нүүсэн
4.	Стандарт М ХХК	А\ 58 хавсралтын "5"	СБД 8-р хороо, Хэвлэлийн комбинатын байр	Үйл ажиллагаа зогссон
5.	Бараа, солицоо хил худалдааны нэгтгэл УҮГ	А\ 127 хавсралтын Баян голын " 1"	БГД 5-р хороо, Комплекс импорт нэгдлийн хажууд	Хувьчлагдсан
6.	Ди энд Ди ХХК	А\ 187	БГД 10-р хороо Комплекс импорт нэгдлийн байранд	Байр нь дуудлага худалдаагаар орж өөр байгууллага авсан
7.	СН трейд ХХК	А\187	БГД 18-р хороо Таван эрдэнэ захын урд	Байр нь хүнсний төв ажиллуулах шаардлага хангахгүй
8.	Зэндмэнэ хурх ХХК	А\ 08 хавсралтын Баян голын " 4"	БГД Ган зам зочид буудлын ард	Түрээсийн байр худалдагдсан
9.	Хан Эрдэнэ ХХК	А\ 127 хавсралтын Сүх баатарын " 2"	1-р хороо, Авто тээврийн институтын байранд	Түрээсийн байрыг буцаан өгч өөрсдөө шинээр байртай болсон